



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/07

Амардалай

┌ Эцэг эхийн зөвлөл шинэчлэн байгуулах ┐
тухай

Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Байгууллагын албан хаагчдын гэр бүлийн тогтвортой байдал, эерэг харилцаа хандлага, хүүхдийн хөгжил төлөвшил, хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх зорилгоор "Эцэг эхийн зөвлөл"-ийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Эцэг эхийн зөвлөлийн дарга: Б.Баттогтох (Байгаль орчин хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Ц.Билэг-Ариун (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Гишүүд: Б.Довуучий (1-р багийн Засаг дарга)

Б.Энхдэлгэр (ХХҮ-ний мэргэжилтэн)

Г.Дэжидсүрэн (ЗДТГ-ын нягтлан бодогч)

2. Байгууллагын "Эцэг эхийн зөвлөл"-ийн хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг бүтэн жилээр боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган, тайлан мэдээг цаг хугацаанд нь холбогдох газарт хүргүүлэх, хүүхдийн төлөө шинээр санал санаачлага гарган хэрэгжүүлэх, хүүхдийн өрөөг бэлтгэх зэрэг ажлыг санаачлан ажиллахыг Зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3. 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/06 тоот тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА  С.НАРАНТУНГАЛАГ

